

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.12. Шилэн дансны мэдээлэл	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
3. Менежментийн захидал	10
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан	12
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	13
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	15
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	17
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	18
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	20
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

НАЛАЙХ ДАХЬ МЭРГЭЖЛИЙН
СУРГАЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН
ТӨВИЙН ЗАХИРАЛ Ц.СОНГУУЛЬ
ТАНАА

2020-02-27 № 06/626
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Налайх дахь мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Налайх дахь мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Налайх дахь мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Налайх дахь мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Налайх дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн захирал Ц.Сонгууль Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэн худалдан авалт хийхдээ төлбөрийн баримт /и баримт/-ыг авч хэвших, шилэн дансны болон худалдан авах ажиллагааны цахим хуудсанд мэдээллийг цаг хугацаанд нь байршуулах, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт стандарт, хууль, тушаал, зааварт холбогдох өөрчлөлтүүдийг тусган шинэчилж мөрдөх зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Налайх дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Налайх дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 11 дүгээр сарын 19-ний өдрөөс 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Ихмонгол хөлөг Аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Налайх дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Ихмонгол хөлөг Аудит” ХХК-д 2020 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 33 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Налайх дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь Нийгмийн түншлэл, ажил олгогчдын оролцоог нэмэгдүүлж, хувь хүний чадамжинд суурилсан, мэдээллийн технологид тулгуурласан, ирээдүйг угтсан, насан туршийн боловсрол олгох сургалтын тогтолцоог бий болгож, сургалтын орчныг сайжруулан, багшлах боловсон хүчний чадавхийг дээшлүүлж, төлөвшсөн, чадварлаг мэргэжилтэй ажилтан бэлтгэхэд оршино.

Налайх дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Нийгмийн түншлэл ажил олгогчдын оролцоог нэмэгдүүлэх
- Төгсөгчдийг ажлын байраар хангах
- Сургалтын орчинг сайжруулах
- Багшлах боловсон хүчний чадавхийг үе шаттайгаар дээшлүүлэх
- Гадаад харилцаагаа өргөжүүлж, төсөл хөтөлбөрүүдэд хамрагдах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг дараах хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ;
- Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтийн хэмжээ;
- Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2019 оноос мөрдөж эхэлсэн;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг цахимаар зохион байгуулж нээлттэй мэдээллэх;
- Засгийн газрын “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай” 2019 оны 276 тугаар тогтоолоор цалингийн зэрэглэл өөрчлөгдсөн.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Налайх дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцээгүй байна.

Налайх дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Acolous-4.0” программ хангамж ашигладаг байна.

Налайх дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Налайх дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 15 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1,533,170.4 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 15,331.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд 21,031.8 мянган төгрөгөөр материаллаг түвшин тогтоосон нь тайлант оны суурь үзүүлэлтийн дүнгээс тооцсонтой холбоотой байна.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Налайх дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө, нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн өмнөх оноос 179,908.5 мянган төгрөгөөр буюу 2.1 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	52.0	52.0
Авлага	6,852.5	6,317.5	(535.0)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	196,316.1	190,616.3	(5,699.8)
Үндсэн хөрөнгө	8,547,185.0	8,373,459.3	(173,725.7)
Нийт хөрөнгө	8,750,353.6	8,570,445.1	(179,908.5)
Өр төлбөр	1,272.0	272.9	(999.1)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	8,749,081.6	8,570,172.2	(178,909.4)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	8,750,353.6	8,570,445.1	(179,908.5)

Авлагын оны эхний 6,852.5 мянган төгрөгийн үлдэгдлийг бүрэн барагдуулсан ч, аудитын явцад татварын байгууллагад илүү төлсөн 6,317.5 мянган төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд залруулан тайлагнасан.

Бараа материалын дансны үлдэгдэл буурсан нь 9,241.6 мянган төгрөгийн бараа, материалыг холбогдох шийдвэрийг үндэслэн акталснаас шалтгаалж байна.

Бараа материалын дансны үлдэгдлийн 3.8 хувь буюу 7,196.5 мянган төгрөгийг бичиг хэргийн материал, 28 хувь буюу 53,290.4 мянган төгрөгийг аж ахуйн материал, 0.1 хувь буюу 140.0 мянган төгрөгийг түлш, шатах тослох материал, 1.4 хувь буюу 2,736.1 мянган төгрөгийг хүнсний материал, 66.7 хувь буюу 127,253.3 мянган төгрөгийг бусад хангамжийн материал тус тус эзэлж байна.

Бараа материалын үлдэгдлийн 94.7 хувийг аж ахуйн материал болон бусад хангамжийн материал эзэлж байна. Үүнд: Байгууллага түүний үйл ажиллагаатай холбоотой бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс болон хичээл үйлдвэрлэлд ашиглах багаж, сэлбэг бүртгэлтэй байна.

Үнэ төлбөргүй болон хандиваар хүлээн авсан 122,889.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөөр нэмэгдэж, акталж, данснаас хассан 16,481.6 мянган төгрөгөөр хасагдсан байна.

Налайх дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн биет бус хөрөнгө 2,500.0 төгрөгөөр өсч, тайлант онд байгуулсан 575.0 мянган төгрөгийн элэгдлээр буурсан байна.

Өр төлбөрийн дансны эхний үлдэгдэл гэрэл цахилгаан, түлш халаалтын 1,272.0 мянган төгрөгийн өрийг бүрэн барагдуулж, тайлант хугацаанд татварын байгууллагад төлөх 272.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант хугацаанд 4 хөтөлбөрийн хүрээнд 1,748,417.9 мянган төгрөгийг улсын төсвөөс 10,000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Налайх дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв нь тайлант онд 10,000.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 15,553.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 155.5 хувиар биелүүлсэн байна.

Өөрийн үйл ажиллагаанаас санхүүжих 5,553.5 мянган төгрөгөөр давсан нь түр сургалтуудыг зохион байгуулснаас шалтгаалсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,740,777.3 мянган төгрөг буюу 99 хувьтай байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд төсөвт байгууллагын өөрийн орлогын 18,974.0 мянган төгрөгийг бүрдүүлж, хоол хүнсний зардалд 1,134.0 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардалд 17,840.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 15 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 5 эрсдэл тодорхойлж нийт 20 горим сорил хэрэгжүүлжээ.

Аудитаар нийт 208,910.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 203,623.9 мянган төгрөгийн алдааг залруулж, 2,236.2 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 3,050.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө. Үүнд:

1. Тайлант хугацаанд цалин, хөдөлмөрийн хөлс болон тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан албан татварын тайланд эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийн дүнг 8,266.7 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна. Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, үнэн зөв байх, тодруулга ба толилуулга батламж мэдэгдлүүдийг тус тус хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хувь хүний орлогын албан татварын тайланд залруулсан.

2. Хувь хүний орлогын албан татварын тайланд 945.9 мянган төгрөгийн тохируулга хийгдээгүй байна. Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-т "Энэ хуулийн 11.1.1-11.1.6-д заасан орлогод ногдох жилийн албан татварт дараахь хэмжээгээр албан татварын хөнгөлөлт үзүүлнэ:" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хувь хүний орлогын албан татварын тайланд залруулсан.

3. Хувь хүний орлогын албан татварын тайланд цалин, хөдөлмөрийн хөлс шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого, шууд бус орлогыг нийт 9,806.8 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна.

Шийдвэрлэсэн нь: Хувь хүний орлогын албан татварын тайланд залруулсан.

4. Тайлант хугацаанд ТИКА төслөөр гагнуурын өрөөг тохижуулахад хандивласан 22 төрлийн нийт 57,900.7 мянган төгрөгийн хөрөнгийг орлогод тусгаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв байдал, оршин байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулсан.

5. Тайлант хугацаанд Трансвест Монголиа компаниас хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн гал тогооны 13 төрлийн 23,517.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг нягтлан бодох бүртгэлд бүртгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасан, үнэн зөв байдал, оршин байх батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулсан.

6. Мөнгөн хөрөнгийн журналын дүнг харилцах дансны хуулгатай тулгахад нэр данс зөрүүтэй, буцсан, нийгмийн даатгалын сангийн шилжүүлэг нийт 66,587.7 мянган төгрөгийн гүйлгээг мөнгөн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлд бүртгээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулсан.

7. 2019 оны 8 дугаар сарын 06-ны 36,598.8 мянган төгрөгийн санхүүжилтийн орлогын гүйлгээг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6.4.5-д заасан хугацааг баримтлаагүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, тохиолдсон байх, толилуулга ба илчлэл, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд нөхөж мэдээлсэн.

8. Цалин хөлсний тооцооллыг давтан шалгахад 6 ажилтанд нийт 3,050.0 мянган төгрөгийн хүнд хортой нөхцлийн нэмэгдэл олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-т "Нягтлан бодох бүртгэл хөтөлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2004 оны 77 дугаар тушаалаар баталсан "Тэтгэврийг хөнгөлөлттэй нөхцлөөр тогтоох, газрын дор болон хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарх ажил мэргэжлийн жагсаалт"-тай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын толилуулга ба тодруулга, тохиолдсон байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

9. Дотуур байранд амьдрах нэг хүүхдийн хоногийн хоолны зардал, нормативийг мөрдөж ажиллаагүйгээс 2,041.3 мянган төгрөгөөр илүү зарцуулсан нь Засгийн газрын 2012 оны 106 дугаар тогтоолоор "Мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын дотуур байранд амьдрах нэг хүүхдийн хоногийн хоолны зардал 2315 төгрөг" гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын үнэн зөв байдал, хэмжилт, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

10. Дэд бүтцийн сайдын 2004 оны 19 дүгээр тушаалаар баталсан "Автомашинны 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг нормыг мөрдөөгүйгээс шатахууны зардлыг 194.9 мянган төгрөгөөр хэтрүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах" заалттай нийцэхгүй,

санхүүгийн тайлагналын үнэн зөв байдал, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Хэрэгжиж дуусаагүй төсөл хөтөлбөрүүдтэй холбогдуулан хандивын хөрөнгийн бүртгэл тайлагналыг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Налайх дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 18 мэдээллийг хугацаанд нь, 7 мэдээллийг хугацаа хоцроож байршуулж, аудиторын зөвлөмжийн дагуу 6 мэдээллийг нөхөж мэдээллэсэн.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1,312.6 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосныг 100 хувь барагдуулж, 585.5 мянган төгрөгийн хүүхдийн хоолны нормативыг мөрдөөгүй зөрчлийг арилгах албан шаардлагыг хүргүүлснийг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан байна.

Нийт 3 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Налайх дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Залруулагдаагүй 5,286.2 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон 21,031.8 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул Налайх дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Анхан шатны баримттай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт: Тайлант хугацаанд худалдан авалт хийхдээ зарлагын баримттай боловч төлбөрийн баримт /и баримт/-ыг хавсаргаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.” Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 6.5-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм.” гэж заасан, санхүүгийн тайлагналын үнэн зөв байдал, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл: Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, хууль, тогтоомжийг мөрдөхгүй байх.

3.1.3 Өгсөн зөвлөмж: Худалдан авалт хийхдээ төлбөрийн баримт /и баримт/-ыг авч хэвших.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудиторын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.2 Шилэн данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт: Тайлант хугацаанд 18 удаагийн худалдан авах ажиллагааг харьцуулалтын аргаар зохион байгуулсан ч www.shilendans.gov.mn, www.tender.gov.mn цахим хуудсанд мэдээллээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” гэж заасан санхүүгийн тайлагналын үнэн зөв байдал, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна.

- 3.2.2 Эрсдэл: Худалдан авах ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулахгүй байх
- 3.2.3 Өгсөн зөвлөмж: Шилэн дансны болон худалдан авах ажиллагааны цахим хуудсанд мэдээллийг тогтмол оруулж хэвших, байгууллагын дотоод хяналтыг сайжруулах.
- 3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудиторын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал

- 3.3.1 Илрүүлэлт: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хүчингүй болсон 17, 3.1.8 дугаар заалт, Сангийн сайдын 276 дугаар тушаал, байгууллагын онцлогт нийцэхгүй НББОУС-36, НББОУС-19 стандартуудыг өөрчлөөгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана.” гэж заасан санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна.
-
- 3.3.2 Эрсдэл: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь байгууллагын үйл ажиллагааны онцлог, стандарт, хууль, тушаал, зааварт нийцэхгүй байх.
- 3.3.3 Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт стандарт, хууль, тушаал, зааварт холбогдох өөрчлөлтүүдийг тусган шинэчилж мөрдөх.
- 3.3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудиторын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Эргэлтийн хөрөнгийн дүн	203,168,511.76	196,985,728.51
31	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	-	52,000.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	52,000.00
31110	Төгрөг	-	52,000.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	-
3121	Төгрөг	-	-
31211	Төрийн сангийн харилцах	-	-
33	АВЛАГА	6,852,458.25	6,317,471.50
33100	Ажиллагсадтай холбогдсон авлага	2,059,684.00	6,317,471.50
335	Бусад авлага	4,792,774.25	-
3351	Байгууллагаас авах авлага	4,792,774.25	-
35	БАРАА МАТЕРИАЛ	196,316,053.51	190,616,257.01
354	Хангамжийн материал	196,316,053.51	190,616,257.01
35410	Бичиг хэргийн материал	10,799,610.00	7,196,480.00
35420	Аж ахуйн материал	52,739,957.60	53,290,376.60
35440	Түлш шатах тослох материал	210,000.00	140,000.00
35460	Хүнсний материал	4,134,449.50	2,736,081.00
35470	Бусад хангамжийн материал	128,432,036.41	127,253,319.41
2	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	8,547,185,000.67	8,373,459,346.97
39	Үндсэн хөрөнгө	8,547,185,000.67	8,373,459,346.97
392	Биет хөрөнгө	7,893,654,589.59	7,718,003,935.93
39201	Барилга, байгууламж	7,689,952,576.59	7,689,952,576.59
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	(256,683,178.68)
39203	Авто тээврийн хэрэгсэл	150,517,320.00	150,517,320.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(128,846,617.95)	(144,280,338.36)
39205	Машин, тоног төхөөрөмж	1,454,587,144.76	1,574,614,472.76
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,425,219,682.19)	(1,429,288,703.26)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	386,096,397.02	388,222,090.02
39208	Хуримтлагдсан элэгдэл	(257,403,442.64)	(279,621,097.14)
39217	Номын фонд	23,970,894.00	24,570,794.00
393	Биет бус хөрөнгө	653,530,411.08	655,455,411.04
39303	Бусад биет бус хөрөнгө	673,134,858.00	675,634,858.00
39304	Хасагдуулга	(19,604,446.92)	(20,179,446.96)
3	Нийт хөрөнгийн дүн	8,750,353,512.43	8,570,445,075.48
4	Нийт өр төлбөрийн дүн	1,271,985.78	272,900.00
41	Богино хугацаат өр төлбөр	1,271,985.78	272,900.00
413	Өглөг	1,271,985.78	272,900.00
41310	Ажиллагчидтай холбогдсон өглөг	-	30,800.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,263,985.78	-
4136	Бусад өглөг	8,000.00	242,100.00
41361	Байгууллагад төлөх өглөг	8,000.00	242,100.00
5	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	8,749,081,526.65	8,570,172,175.48
51	Засгийн газрын хувь оролцоо	8,749,081,526.65	8,570,172,175.48
511	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	2,346,405,152.09	2,346,405,152.09
51101	Өмч: -Төрийн өмч	2,346,405,152.09	2,346,405,152.09
512	Хуримтлагдсан үр дүн	(1,458,987,641.15)	(1,637,227,050.32)
51210	Өмнөх үеийн үр дүн	(1,458,987,641.15)	(1,458,317,699.15)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(178,909,351.17)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	7,861,664,015.71	7,860,994,073.71
6	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	8,750,353,512.43	8,570,445,075.48

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үйл ажиллагааны орлогын дүн (i)	1,494,857,448.33	1,924,268,978.00
12	Татварын бус орлого	101,577,148.33	175,851,078.00
120	Нийтлэг татварын бус орлого	101,577,148.33	175,851,078.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	101,284,374.08	175,851,078.00
